



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН
2025 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА



АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	3
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	4
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	5
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	6
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	8
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	8
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	10
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд...11	
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	12
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	13
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	13
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	14
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	14
3.4 Зээлийн чанарын талаар.....	15
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	18
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	18
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	19
4.3 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн талаар.....	20
4.4 Санхүүгийн бус өр төлбөр.....	20
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	21
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	21
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	22
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	22
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	22
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	23
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	24
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	24

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2025 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025.08.28

Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2025 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 177 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 ХЗХ буюу 2.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Нийт ХЗХ-дын 52.0 хувь буюу 92 ХЗХ орон нутагт, 48.0 хувь буюу 85 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо (хот, орон нутгаар)



Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 3 ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох, 2 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 29 ХЗХ-ны 286 сонгуульт гишүүн (давхардсан тоогоор), 14 ХЗХ-ны гүйцэтгэх захирал, нягтлан бодогчийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2021	2022	2023	2024	2025.И
ХЗХ-ны тоо	209	196	191	178	177
Шинээр олгосон	-	7	3	4	4
Хүчингүй болгосон	40	20	8	17	5
Түдгэлзүүлсэн	12	4	10	4	2
Сэргээсэн	1	3	1	2	-
ТЗ-ийн хугацаа сунгасан	85	62	-*	-*	-*

*Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2023.01.06-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.

ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 7.0 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бол гишүүдийн тоо дунджаар 1.3 хувиар, тэр дундаа орон нутгийн гишүүдийн тоо 6.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 2: ХЗХ-дын тоо, гишүүдийн мэдээлэл (хот, орон нутаг)

	2021.И	2022.И	2023.И	2024.И	2025.И	Дүрсгэл
Нийт ХЗХ-дын тоо	234	200	192	181	177	■ ■ ■ ■ ■
Улаанбаатар	136	110	101	92	85	■ ■ ■ ■ ■
Орон нутаг	98	90	91	89	92	■ ■ ■ ■ ■
Нийт гишүүдийн тоо	73,719	72,566	71,184	74,186	76,879	■ ■ ■ ■ ■
Улаанбаатар	43,322	40,830	38,729	40,245	40,689	■ ■ ■ ■ ■
Орон нутаг	30,397	31,736	32,455	33,941	36,190	■ ■ ■ ■ ■


1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2025 оны 2 дугаар улирлын байдлаар 177 ХЗХ 63 салбар, 593 ажилтан, 76,879 гишүүн (76,514 иргэн, 365 хуулийн этгээд)-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотод Багахангай дүүргээс бусад дүүрэгт 85 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 ХЗХ буюу 7.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдэд төвлөрөл хамгийн их байна.

Монгол Улсын 21 аймагт 92 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 ХЗХ буюу 3.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2: ХЗХ-дын тархалт



Зураг 1: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2025 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,693 буюу 3.6 хувиар өсөж 76,879-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 53.9 хувь буюу 41,469 нь эмэгтэй, 0.5 хувь буюу 365 нь хуулийн этгээд, үүний 47.1 хувь буюу 172 нь эмэгтэй удирдлагатай байна.

Зураг 3: ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 52.9 хувь буюу 40,689 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 47.1 хувь буюу 36,190 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт (хот, орон нутгаар)




Нийт 177 ХЗХ-ны 28.3 хувь буюу 50 ХЗХ 20-100 гишүүнтэй, 53.7 хувь буюу 95 ХЗХ 101-500 гишүүнтэй, 10.7 хувь буюу 19 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 7.3 хувь буюу 13 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна. 1,001-ээс дээш гишүүнтэй ХЗХ-дын 53.8 хувь буюу 7 ХЗХ Улаанбаатар хотод, 46.2 хувь буюу 6 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 3: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд (интервалаар)	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	50	2,677	3.5%
101-500 гишүүнтэй	95	22,234	28.9%
501-1,000 гишүүнтэй	19	13,956	18.2%
1,001-ээс дээш гишүүнтэй	13	38,012	49.4%
Нийт	177	76,879	100.0%

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 13 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 49.4 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



1.4 Бодлого, зохицуулалтын орчин

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хадгаламж, зээлийн хоршооны салбарын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээ.

- Улсын Их Хурлын даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 258 дугаар захирамжаар Санхүүгийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлал, дагалдах хууль, үр нөлөөний үнэлгээ, ХЗХ-дын 2025 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн хураангуй танилцуулга зэрэг баримт бичгийг ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа болон ажлын хэсгийн гишүүдэд 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн.

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын хэрэгжилт

- Хуульд заасны дагуу 2024 оны тайланг аудитаар баталгаажуулж ирүүлбэл зохих 171 ХЗХ-оос тайлант улирлын байдлаар 87.1 хувь буюу 149 ХЗХ жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

- 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 14 ХЗХ Монголбанкны СМА-д 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 6,468,037.93 мянган төгрөгийн 137 гүйлгээг мэдээлсэн бөгөөд сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

- ХЗХ-д Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй. 2025 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 177 ХЗХ-ны 61.6 хувь буюу 109 ХЗХ зээлийн мэдээллийн санд хамрагдаж, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. Үүнээс 52.3 хувь буюу 57 ХЗХ нийслэлд, 47.7 хувь буюу 52 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

- 2025 оны 2 дугаар улирлын байдлаар зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлбэл зохих 95 ХЗХ-оос 61 ХЗХ 44,033.00 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА


- Азийн Хөгжлийн Банктай 2022-2025 онд хамтран хэрэгжүүлсэн ТА-6883REG: “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азид жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх” төслийн хүрээнд ХЗХ-дод зориулсан “Хүртээмжтэй ногоон санхүү”, сургагч багш нарт зориулсан “Жендерийн мэдрэмжтэй ногоон санхүү” гарын авлагыг тус тус хэвлүүлсэн. Мөн “CAREC”-ийн орнуудын хооронд туршлага судлах цахим уулзалтыг зохион байгуулж, уулзалтад Пакистан, Узбекистан улсын төв банк болон холбогдох яамдын төлөөлөл, Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /ACCU/, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны төлөөлөл оролцож ХЗХ-дод тулгарч байгаа жендер болон ногоон санхүүгийн асуудлаар туршлага солилцсон.
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/76 тоот тушаалаар “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж, тайлагнах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулагдсан бөгөөд төрийн байгууллагууд болон ХЗХ-ны төлөөллүүд хамтран хадгаламж, зээлийн хоршооны салбарын эмзэг байдлыг үнэлж байна.

Нийт гишүүдийн 45 хувь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр буюу дээд боловсролтой нийт гишүүдийн 66.3 хувь Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байна.

ХЗХ-дын нийт гишүүдийн 55.3 хувийг 18-45 насныхан эзэлж байна. Гишүүдийн насжилтыг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн

насжилт орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс харьцангуй залуу байна.

График 5: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин (хот, орон нутгаар)



Хүснэгт 5: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт зээлдэгч		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	177	100.0%	85	48.0%	92	52.0%
Нийт зээлийн үлдэгдэл	294,770,870.43	100.0%	219,875,056.59	74.6%	74,895,813.84	25.4%
Нийт зээлдэгчийн тоо	28,937	100.0%	12,532	43.3%	16,405	56.7%
Иргэн	28,812	99.6%	12,420	99.1%	16,392	99.9%
Эмэгтэй	16,694	57.9%	7,365	59.3%	9,329	56.9%
Хуулийн этгээд	125	0.4%	112	0.9%	13	0.1%
Эмэгтэй удирдлагатай	53	42.4%	44	39.3%	9	69.2%
Зээлдэгчдийн насжилт	28,812	100.0%	12,420	43.1%	16,392	56.9%
18-35 насны	7,248	25.2%	3,338	26.9%	3,910	23.9%
36-45 насны	8,760	30.4%	4,073	32.8%	4,687	28.6%
46-55 насны	6,985	24.2%	2,775	22.3%	4,210	25.7%
55-аас дээш	5,819	20.2%	2,234	18.0%	3,585	21.9%
Зээлдэгчдийн боловсрол	28,812	100.0%	12,420	43.1%	16,392	56.9%
Дээд	11,543	40.1%	6,628	53.4%	4,915	30.0%
Тусгай дунд	3,810	13.2%	1,275	10.3%	2,535	15.5%
Бүрэн дунд	6,880	23.9%	2,182	17.6%	4,698	28.7%
Дунд	5,320	18.5%	2,246	18.1%	3,074	18.8%
Бага	1,259	4.4%	89	0.7%	1,170	7.1%

Тайлант улиралд ХЗХ-д 28,937 зээлдэгчийн 294,770,870.43 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 43.3 хувь буюу 12,532 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 74.6 хувь буюу 219,875,056.59 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 56.7 хувь буюу 16,405 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 25.4 хувь буюу 74,895,813.84 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Нийт зээлдэгчийн 99.6 хувь буюу 28,812 нь хувь хүн (57.9 хувь буюу 16,694 нь эмэгтэй), 0.4 хувь буюу 125 нь хуулийн этгээд байна.

Нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 10,186.64 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 17,545.09 мянган төгрөг, орон нутагт 4,565.43 мянган төгрөг байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт		Үүнээс:		Орон нутаг	
	хадгаламж эзэмшигч		Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	177	100.0%	85	48.0%	92	52.0%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	259,445,446.67	100.0%	198,744,732.28	76.6%	60,700,714.39	23.4%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	48,817	100.0%	26,444	54.2%	22,373	45.8%
Иргэн	48,716	99.8%	26,383	99.8%	22,333	99.8%
<i>Эмэгтэй</i>	26,721	54.9%	13,063	49.5%	13,658	61.2%
Хуулийн этгээд	101	0.2%	61	0.2%	40	0.2%
<i>Эмэгтэй удирдлагатай</i>	52	51.5%	17	27.9%	35	87.5%
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	8,617,531.97	3.3%	6,934,183.39	3.5%	1,683,348.58	2.8%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	7,068	14.5%	5,806	22.0%	1,262	5.6%
Иргэн	7,020	14.4%	5,761	21.8%	1,259	5.6%
Хуулийн этгээд	48	0.1%	45	0.2%	3	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	250,827,914.69	96.7%	191,810,548.89	96.5%	59,017,365.80	97.2%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	41,749	85.5%	20,638	78.0%	21,111	94.4%
Иргэн	41,696	85.4%	20,622	78.0%	21,074	94.2%
Хуулийн этгээд	53	0.1%	16	0.1%	37	0.2%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	48,716	100.0%	26,383	100.0%	22,333	100.0%
18-35 насны	16,834	34.6%	11,345	43.0%	5,489	24.6%
36-45 насны	12,272	25.2%	5,940	22.5%	6,332	28.4%
46-55 насны	10,230	21.0%	4,719	17.9%	5,511	24.7%
56-аас дээш	9,380	19.3%	4,379	16.6%	5,001	22.4%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	48,716	100.0%	26,383	100.0%	22,333	100.0%
Дээд	20,537	42.2%	13,699	51.9%	6,838	30.6%
Тусгай дунд	6,443	13.2%	3,267	12.4%	3,176	14.2%
Бүрэн дунд	10,686	21.9%	4,562	17.3%	6,124	27.4%
Дунд	6,490	13.3%	2,046	7.8%	4,444	19.9%
Бага	4,560	9.4%	2,809	10.6%	1,751	7.8%

2025 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-д 48,817 хадгаламж эзэмшигчийн 259,445,446.67 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 54.2 хувь буюу 26,444 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 76.6 хувь буюу 198,744,732.28 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 45.8 хувь буюу 22,373 хадгаламж эзэмшигч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 23.4 хувь буюу 60,700,714.39 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2025 оны 2 дугаар улирлын байдлаар зах зээлийн нийт хөрөнгө 376,872,464.28 мянган төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.0 хувь буюу 49,070,400.68 мянган төгрөгөөр өсөж, банкны зах зээлийн 0.5 хувьтай тэнцэж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 14.5 хувийг хугацаагүй, 85.5 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 48,716 нь хувь хүн (54.9 хувь буюу 26,721 нь эмэгтэй), 0.2 хувь буюу 101 нь хуулийн этгээд (51.5 хувь буюу 52 нь эмэгтэй удирдлагатай) байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,314.65 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,515.68 мянган төгрөг, орон нутагт 2,713.12 мянган төгрөг байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 21.1 хувь буюу 51,433,259.01 мянган төгрөгөөр, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 14.7 хувь буюу 33,320,140.78 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 23.6 хувь буюу 8,516,531.60 мянган төгрөгөөр, нийт зарлага 20.5 хувь буюу 6,197,954.99 мянган

төгрөгөөр нэмэгдэж нийт цэвэр орлого 8,153,492.71 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ

үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай нийт ХЗХ-дын 61.6 хувь буюу 109 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны II	2025 оны II	Өөрчлөлт	
	улирал	улирал	Дүн	Хувь
Нийт хөрөнгө	327,802,063.60	376,872,464.28	49,070,400.68	15.0%
Банкны салбарт эзлэх хувь	0.5%	0.5%		
Нийт зээл	243,337,611.42	294,770,870.43	51,433,259.01	21.1%
Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.7%		
Нийт чанаргүй зээл	6,824,289.53	6,996,330.36	172,040.83	2.5%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.8%	2.4%	-0.4%	-15.2%
Банкны салбарт эзлэх хувь	0.4%	0.3%	-0.1%	-15.1%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	226,125,305.89	259,445,446.67	33,320,140.78	14.7%
Банкны салбарт эзлэх хувь	1.0%	1.0%		
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	28,554,180.27	29,658,416.39	1,104,236.12	3.9%
Нийт хоршоологчдын өмч	44,263,345.75	52,165,434.35	7,902,088.60	17.9%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	7,765,682.24	4,763,700.50	-3,001,981.74	-38.7%
Нийт орлого	36,023,133.41	44,539,665.01	8,516,531.60	23.6%
Нийт зарлага	30,188,217.31	36,386,172.30	6,197,954.99	20.5%
Цэвэр орлого, алдагдал	5,834,916.10	8,153,492.71	2,318,576.61	39.7%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 85 ХЗХ-ны нийт хөрөнгө 287,745,215.44 мянган төгрөг нь зах зээлийн 76.4 хувь, нийт зээл 219,875,056.59 мянган төгрөг нь зах зээлийн 74.6 хувь, нийт хадгаламж 198,744,732.28 мянган төгрөг нь зах зээлийн 76.6 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 хувь буюу 67,884.76 мянган төгрөгөөр өсч 5,604,448.06 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 2.5 хувийг эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 23.3 хувь буюу

6,179,823.41 мянган төгрөгөөр, нийт зарлага 19.7 хувь буюу 4,395,079.61 мянган төгрөгөөр, цэвэр орлого 1,784,743.80 мянган төгрөгөөр өсөж 5,958,533.12 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 67.1 хувь буюу 57 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны II	2025 оны II	Өөрчлөлт	
	улирал	улирал	Дүн	Хувь
Нийт хөрөнгө	254,687,387.38	287,745,215.44	33,057,828.06	13.0%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	77.7%	76.4%	-1.3%	-1.7%
Нийт зээл	184,262,662.61	219,875,056.59	35,612,393.98	19.3%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	75.7%	74.6%	-1.1%	-1.5%
Нийт чанаргүй зээл	5,536,563.30	5,604,448.06	67,884.76	1.2%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	81.1%	80.1%	-1.0%	-1.2%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.0%	2.5%	-0.5%	-15.0%

Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	176,993,055.92	198,744,732.28	21,751,676.36	12.3%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	78.3%	76.6%	-1.7%	-2.2%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	20,601,184.12	20,910,295.82	309,111.70	1.5%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	72.1%	70.5%	-1.6%	-2.2%
Нийт хоршоологчдын өмч	32,998,560.84	38,437,030.40	5,438,469.56	16.5%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	74.6%	73.7%	-0.9%	-1.2%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	7,633,918.95	4,544,035.17	-3,089,883.78	-40.5%
Нийт орлого	26,525,292.28	32,705,115.69	6,179,823.41	23.3%
Нийт зарлага	22,351,502.96	26,746,582.57	4,395,079.61	19.7%
Цэвэр орлого, алдагдал	4,173,789.32	5,958,533.12	1,784,743.80	42.8%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 92 ХЗХ-ны нийт хөрөнгө 89,127,248.83 мянган төгрөг нь зах зээлийн 23.6 хувь, нийт зээлийн үлдэгдэл 74,895,813.84 мянган төгрөг нь зах зээлийн 25.4 хувь, нийт хадгаламж 60,700,714.39 мянган төгрөг нь зах зээлийн 23.4 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 24.6 хувь буюу 2,336,708.21 мянган төгрөгөөр, нийт зарлага 23.0 хувь буюу 1,802,875.39 мянган төгрөгөөр тус тус өсөж, нийт цэвэр орлого

2,194,959.59 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 56.5 хувь буюу 52 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 9: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны II	2025 оны II	Өөрчлөлт	
	улирал	улирал	Дүн	Хувь
Нийт хөрөнгө	73,114,676.22	89,127,248.83	16,012,572.61	21.9%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	22.3%	23.6%	1.3%	6.1%
Нийт зээл	59,074,948.81	74,895,813.84	15,820,865.03	26.8%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	24.3%	25.4%	1.1%	4.6%
Нийт чанаргүй зээл	1,287,726.23	1,391,882.30	104,156.07	8.1%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	18.9%	19.9%	1.0%	5.3%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.7%	0.6%	-0.1%	-9.6%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	49,132,249.97	60,700,714.39	11,568,464.42	23.5%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	21.7%	23.4%	1.7%	7.8%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	7,952,996.14	8,748,120.57	795,124.43	10.0%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	27.9%	29.5%	1.6%	5.7%
Нийт хоршоологчдын өмч	11,264,784.91	13,728,403.94	2,463,619.03	21.9%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	25.4%	26.3%	0.9%	3.6%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	131,763.30	219,665.33	87,902.03	66.7%
Нийт орлого	9,497,841.12	11,834,549.33	2,336,708.21	24.6%
Нийт зарлага	7,836,714.35	9,639,589.74	1,802,875.39	23.0%
Цэвэр орлого, алдагдал	1,661,126.77	2,194,959.59	533,832.82	32.1%

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц (мянган төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	2024 оны II улирал		2025 оны II улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ	318,612,812.71	97.2%	362,473,506.79	96.2%	43,860,694.08	13.8%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	65,829,773.21	20.1%	52,797,535.43	14.0%	-13,032,237.77	-19.8%
Бэлэн мөнгө	3,659,524.30	1.1%	3,945,446.99	1.1%	285,922.69	7.8%
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	15,828,782.34	4.8%	16,202,800.65	4.3%	374,018.31	2.4%
Банканд байршуулсан хадгаламж	42,807,172.66	13.1%	32,498,612.16	8.6%	-10,308,560.51	-24.1%
Замд яваа мөнгө	11,762.63	0.0%	2,027.12	0.0%	-9,735.41	-82.8%
Мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	-	-	-	-	0.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,522,531.37	1.1%	148,648.52	0.0%	-3,373,882.86	-95.8%
Зээл (цэвэр)	246,642,405.96	75.2%	303,115,300.83	80.4%	56,472,894.87	22.9%
Нийт зээл	243,337,611.42	74.2%	294,770,870.43	78.2%	51,433,259.02	21.1%
Хэвийн зээл	229,313,103.31	70.0%	274,160,437.88	72.7%	44,847,334.57	19.6%
Хугацаа хэтэрсэн зээл	7,200,218.58	2.2%	13,614,102.19	3.6%	6,413,883.62	89.1%
Чанаргүй зээл	6,824,289.53	2.1%	6,996,330.36	1.9%	172,040.83	2.5%
Зээлийн хойшлогдсон орлого	-	-	-	-	-	0.0%
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8,204,030.84	2.5%	14,036,995.44	3.7%	5,832,964.59	71.1%
(Зээлийн эрсдэлийн сан)	4,899,236.30	1.5%	5,692,565.05	1.5%	793,328.75	16.2%
Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бусад санхүүгийн хөрөнгө	6,140,633.54	1.9%	6,560,670.53	1.8%	420,036.99	6.8%
Дансны авлага (цэвэр)	1,664,685.26	0.5%	4,120,965.93	1.1%	2,456,280.68	147.6%
Дансны авлага	1,664,685.26	0.5%	4,136,578.03	1.1%	2,471,892.77	148.5%
Хувь хүнээс авах авлага	749,803.62	0.2%	650,911.82	0.2%	-98,891.80	-13.2%
Хуулийн этгээдээс авах авлага (Авлагын эрсдэлийн сан)	914,881.63	0.3%	3,485,666.21	0.9%	2,570,784.57	281.0%
Холбоотой талаас авах авлага	3,752,965.00	1.1%	2,228,434.40	0.6%	-1,524,530.60	-40.6%
Ажиллагчдаас авах авлага	8,511.80	0.0%	9,712.16	0.0%	1,200.36	14.1%
Салбар хоорондын тооцоо	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгө (цэврээр)	142,409.62	0.0%	190,418.63	0.1%	48,009.01	33.7%
Бусад	572,061.88	0.2%	11,139.41	0.0%	-560,922.47	-98.1%
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ	9,189,250.89	2.8%	14,398,957.49	3.8%	5,209,706.60	56.7%
Татварын авлага	405,170.63	0.1%	222,298.21	0.1%	-182,872.42	-45.1%
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	4,038.82	0.0%	7,797.13	0.0%	3,758.31	93.1%
Урьдчилж төлсөн зардал тооцоо	3,232,037.89	1.0%	3,406,117.85	0.9%	174,079.96	5.4%
Бараа материал	291,592.95	0.1%	370,664.14	0.1%	79,071.19	27.1%
Өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	674,508.42	0.2%	983,868.69	0.3%	309,360.27	45.9%
Бусад санхүүгийн бус хөрөнгө	122,914.28	0.0%	2,272,971.23	0.6%	2,150,056.95	1,749.2%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (цэврээр)	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Үндсэн хөрөнгө (цэврээр)	4,343,012.23	1.3%	4,901,019.73	1.3%	558,007.50	12.8%
Биет бус хөрөнгө (цэврээр)	115,975.67	0.0%	2,234,220.51	0.6%	2,118,244.84	1,826.5%
ХӨРӨНГИЙН ДҮН	327,802,063.60	100.0%	376,872,464.28	100.0%	49,070,400.68	15.0%

2025 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 376,872,464.28 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.0 хувь буюу 49,070,400.68 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 96.2 хувийг санхүүгийн хөрөнгө, 3.8 хувийг санхүүгийн

бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт хөрөнгийн 14.0 хувийг, цэвэр зээл 80.4 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс (мянган төгрөгөөр)



Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 21.1 хувь буюу 51,433,259.02 мянган төгрөгөөр өсөж 294,770,870.43 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,692,565.05 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна. Харин чанаргүй зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 хувь буюу 172,040.83 мянган төгрөгөөр өсөж 6,996,330.36 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 89.1 хувь буюу 6,413,883.62 мянган төгрөгөөр өсөж 13,614,102.19 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад дунджаар 10.1 хувиар өссөн. Нийт зээлийн хэмжээ дунджаар 12.5 хувиар өссөн бол чанаргүй зээлийн хэмжээ дунджаар 0.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгө, зээлийн багцын өөрчлөлт (тэрбум төгрөгөөр)


	2021.П	2022.П	2023.П	2024.П	2025.П	Дүрслэл
ХЗХ-ны тоо	234	200	192	181	177	
Нийт хөрөнгө	270.5	271.6	295.9	327.8	376.9	
Нийт зээл	186.8	217.8	220.4	243.3	294.8	
Чанаргүй зээл	7.0	7.2	7.3	6.8	7.0	

3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 5 ХЗХ-ны нийт хөрөнгө 221,514,889.34 мянган төгрөг ба зах зээлийн нийт хөрөнгийн 58.8 хувийг, гишүүдийн тоо 19,943 байгаа нь нийт гишүүдийн 25.9 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд		
			Дүн	Хувь	Тоо	Хувь	
1	10,000,000.0-аас дээш	5	221,514,889.34	58.8%	19,943	25.9%	
2	1,000,000.0 -10,000,000.0	38	121,241,167.29	32.2%	33,113	43.1%	
3	500,000.0-1,000,000.0	22	14,853,593.33	3.9%	7,795	10.1%	
4	100,000.0-500,000.0	70	16,969,665.66	4.5%	13,119	17.1%	
5	50,000.0-100,000.0	25	1,897,340.72	0.5%	2,038	2.7%	
6	10,000.0-50,000.0	15	390,752.44	0.1%	826	1.1%	
7	10,000.0 хүртэл	2	5,055.50	0.0%	45	0.1%	
Нийт дүн			177	376,872,464.28	100.0%	76,879	100.0%



3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 294,770,870.43 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 78.2 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 303,115,300.83 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 80.4 хувийг тус тус эзэлж байна. Нягтлан бодох бүртгэлийн журам шинэчлэгдсэнээр цэвэр зээлийн үндсэн

дансанд хамаарах бусад нэрийн дансуудыг нэмэгдсэнээр тооцоолсон болно.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.17 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.26 хувь байгаа бол Улаанбаатар хотын ХЗХ-дын жигнэсэн

дундаж хүү 1.99 хувь, орон нутгийн ХЗХ-дын жигнэсэн дундаж хүү 2.69 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 36 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 88.7 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 13: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	36	261,506,112.17	88.7%
2	500,000.0-1,000,000.0	20	14,305,595.33	4.9%
3	100,000.0-500,000.0	67	16,305,731.54	5.5%
4	50,000.0-100,000.0	27	2,041,321.12	0.7%
5	10,000.0-50,000.0	19	597,163.85	0.2%
6	10,000.0 хүртэл	4	14,946.42	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	4	-	-
Нийт дүн		177	294,770,870.43	100%

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 14: Зээлийн ангиллын мэдээлэл (мянган төгрөгөөр)


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	28,937	100.0%	294,770,870.43	100.0%
Хэвийн	26,849	92.8%	274,160,437.88	93.0%
Хугацаа хэтэрсэн	853	2.9%	13,614,102.19	4.6%
Чанаргүй	1,235	4.3%	6,996,330.36	2.4%
<i>Хэвийн бус</i>	373	30.2%	1,987,713.42	28.4%
<i>Эргэлзээтэй</i>	287	23.2%	1,664,713.91	23.8%
<i>Муу</i>	575	46.6%	3,343,903.03	47.8%

2025 оны 2 дугаар улирлын байдлаар зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 93.0 хувь буюу 274,160,437.88 мянган төгрөгийг хэвийн зээл, 4.6 хувь буюу 13,614,102.19 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 2.4 хувь буюу 6,996,330.36 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 20,610,432.55 мянган төгрөгийн үлдэгдэлд 27.6 хувь буюу 5,692,565.05 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна. Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 92.8 хувийг хэвийн, 2.9 хувийг хугацаа хэтэрсэн, 4.3 хувийг чанаргүй зээлдэгч эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,235 зээлдэгчийн 6,996,330.36 мянган төгрөгийн үлдэгдлийн 28.4 хувийг

хэвийн бус, 23.8 хувийг эргэлзээтэй, 47.8 хувийг муу зээлийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 пунктээр буурч 93.0 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 1.6 пунктээр өсөж 4.6 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.4 пунктээр буурч 2.4 хувь болсон үзүүлэлттэй байна.

График 6: Зээлийн чанар




